



ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны
04 дүгээр сарын 30-ны өдрийн R-2025-21 дүгээр тогтоолын Хавсралт 2



**ХАСБАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ЗАСАГЛАЛ, ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРООНЫ ДҮРЭМ**

Хувилбар	1.0
Баталсан огноо	2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр
Баталсан	Төлөөлөн удирдах зөвлөл
Боловсруулсан	Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын алба
Холбогдох эрх зүйн баримт бичгүүд	<ul style="list-style-type: none"> ▪ Компанийн тухай хууль ▪ Санхүүгийн зохицуулах хорооны Компанийн засаглалын кодекс ▪ ХасБанкны засаглалын кодекс ▪ ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам
Дагаж мөрдөх Нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх, хүчингүй болгох	<p>Төлөөлөн удирдах зөвлөл</p> <p>Төлөөлөн удирдах зөвлөл</p>

АГУУЛГА

1. НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ХОРООНЫ ЗОРИЛГО
2. ХОЁРДУГААР ЗҮЙЛ. ХОРООНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, БҮТЭЦ
3. ГУРАВДУГААР ЗҮЙЛ. ХОРООНЫ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА
4. ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. ХУРАЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА
5. ТАВДУГААР ЗҮЙЛ. ТАЙЛАГНАЛ
6. ЗУРГАДУГААР ЗҮЙЛ. БУСАД

Нэгдүгээр зүйл. Хорооны зорилго

- 1.1. ХасБанк ХК (“Банк”)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн Засаглал, цалин урамшууллын хороо (“Хороо”)-г ТУЗ-өөс компанийн засаглалын үр нөлөөтэй тогтолцоог хангах, Банкны ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон тулхүүр ажилтанд олгох цалин урамшууллын бүтэц, бодлогод хяналт тавих зорилгоор байгуулна. Хороо нь цалин урамшууллыг Банкны стратеги зорилт, эрсдэлийн удирдлагын тогтолцоо болон хувьцаа эзэмшигчдийн урт хугацааны ашиг сонирхолд нийцүүлнэ.

Хоёрдугаар зүйл. Хорооны зохион байгуулалт, бүтэц

- 2.1. Хороо нь ТУЗ-ийн 6 (зургаа)-аас доoshгүй гишүүдээс бүрдэх бөгөөд үүнээс гуравны хоёр нь ТУЗ-ийн хараат бус, гүйцэтгэх удирдлагын бус гишүүн байна.
- 2.2. Хорооны даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор Хорооны гишүүдийн саналаар сонгоно. ТУЗ-ийн даргын саналыг Хорооны гишүүд заавал дагаж мөрдөх үүрэггүй болно.
- 2.3. Хорооны дарга хуралд оролцохгүй тохиолдолд тухайн хурлыг даргалах этгээдийг нэр дэвшүүлнэ. Хорооны дарга хурлыг даргалах этгээдийг нэр дэвшүүлээгүй бол тухайн хуралд оролцож байгаа гишүүд дундаасаа нэг гишүүнийг сонгож хурлын туршид даргалах түр орлон гүйцэтгэгчийг сонгоно.
- 2.4. Хорооны гишүүд цогцоор компанийн засаглал, ур чадварын удирдлага болон байгууллагын хөгжил зэрэг Банкны зорилго, стратеги төлөвлөлтөд шаардлагатай олон талт мэдлэг, чадвар, дадалыг эзэмшсэн байна. Гишүүн бүр холбогдох хууль тогтоомж болон засаглалын чиг хандлагын талаарх мэдлэгээ шинэчилж байна.
- 2.5. ТУЗ өөрийн зохистой гэж үзсэн хугацаагаар Хорооны гишүүдийг томилох буюу улируулан томилж болно. ТУЗ нь аль ч үед тодорхой шалтгаантай эсэхээс үл хамаарч Хорооны гишүүн болон Хорооны даргыг чөлөөлөх, солих бүрэн эрхтэй.

Гуравдугаар зүйл. Хорооны үүрэг, хариуцлага

- 3.1. Хороо нь компанийн засаглалтай холбоотой дараах болон бусад үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:
 - 3.1.1. Компанийн засаглалын бодлого, журмын хэрэгжилтийг хянах, санал болгох, хяналт тавих, мөн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Хорооны дүрэм, Ёс зүйн дүрэм зэрэг Банкны засаглалд хамаарах баримт бичгүүдийг тогтмол хянах, нэмэлт, өөрчлөлт оруулах санал өгөх;
 - 3.1.2. Монголбанкны засаглалын журам болон Санхүүгийн зохицуулах хорооны Компанийн засаглалын кодекс зэрэг компанийн засаглалын стандарт, хууль тогтоомжийн шаардлага болон ёс зүйн хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг хянах, ТУЗ-д тогтмол тайлagnах, Банкны тухайн жилийн тайландаа оруулах жил бүрийн засаглалын мэдэгдлийг үнэн зөв, бүрэн, хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн хянах, батлах, ТУЗ-д санал болгох;
 - 3.1.3. Банкны засаглал болон стратеги чиглэлд үр дүнтэй хяналт тавих болон нийцлийг хангах зорилгоор ТУЗ-ийн бүтцийг тогтмол үнэлэх, сайжруулах санал гаргах;
 - 3.1.4. ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын ашиг сонирхлын зөрчлийг хууль тогтоомжид заасан шаардлага, компанийн сайн засаглалын зарчмууд, Банкны

Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журамд нийцүүлэн цаг тухайд нь мэдүүлэх, баримтжуулах, тохирсон шийдвэр гаргах болон толилуулж байгаа эсэхийг хянах, шалгах, зохицуулах; ТУЗ-ийн гишүүд, тэр дундаа ТУЗ-ийн хараат бус гишүүдийн хараат бус байдлыг тогтоох, хадгалах үйл явцад хяналт тавих; мөн

- 3.1.5. Банкны дотоод мэдээлэл эзэмшигчийн өрөнхий журмыг боловсруулж хэрэгжилтэд хяналт тавих.
- 3.2. Хороо нь цалин урамшуулалтай холбоотой дараах болон бусад үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:
 - 3.2.1. Банкны стратеги зорилт, хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолд нийцүүлэн Банкны цалин урамшууллын өрөнхий журмыг боловсруулах, ТУЗ-д санал болгох;
 - 3.2.2. Гүйцэтгэх Захирал (“ГЗ”), гүйцэтгэх удирдлага болон бусад ажилтанд олгох тогтмол цалин, гүйцэтгэлд сууринсан урамшуулал, хувьцаанд сууринсан урамшуулал болон бусад хувьсах цалин урамшуулал зэрэг Банкны жил бүрийн цалин урамшууллын бүтцийг боловсруулах, ТУЗ-д санал болгох;
 - 3.2.3. Банкны стратеги зорилт, хууль тогтоомж болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолд нийцүүлэн ТУЗ-ийн гишүүдэд олгох хөлсний хэмжээ, холбогдох бодлогыг хянах, ТУЗ-д танилцуулах;
 - 3.2.4. Цалин урамшууллын тогтолцоог холбогдох салбарын жишигтэй тогтмол харьцуулж, зохих өөрчлөлтийг ТУЗ-д санал болгох;
 - 3.2.5. ГЗ-ын жилийн гүйцэтгэлийн зорилтыг боловсруулж ТУЗ-д санал болгох, батлагдсан зорилттой бодит гүйцэтгэлийг харьцуулан үнэлэх, үнэлгээний үр дүнд үндэслэн урамшуулал болон урт хугацаат урамшуулал зэрэг гүйцэтгэлд сууринсан урамшууллын хэмжээг санал болгох; мөн
 - 3.2.6. ГЗ-тай байгуулах хөдөлмөрийн гэрээнд тусгах түүний цалин урамшуулалтай холбоотой нөхцөлийн талаар хэлэлцэн тохирох, тодорхойлох, ТУЗ-д батлуулахаар санал болгох.
- 3.3. Хороо нь өөрийн үүрэг, хариуцлагатай холбоотой тодорхой асуудлуудад зориулсан тухайлсан бодлого, журамтай байж болох бөгөөд тэдгээр нь ТУЗ-өөс баталсан, энэхүү Дүрэмтэй нийцсэн байна. Тухайн баримт бичгүүд нь энэ Дүрмийн салшгүй нэг хэсэг болох бөгөөд Хороо нь тэдгээрийг чанд дагаж мөрдөнө. Хороо энэ Дүрэм болон холбогдох баримт бичгүүдийг зөрчсөн тохиолдолд ТУЗ-ийн өмнө хариуцлага хүлээнэ.

Дөрөвдүгээр эзүл. Хурал, үйл ажиллагаа

- 4.1. Хорооны хурал болон үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг Банкны ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд зааснаар зохицуулна.
- 4.2. Хорооны зөвлөмж болон шийдвэрийг тухайн хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонх (гуравны хоёр)-ын саналаар батална.

Тавдугаар зүйл. Тайлагнал

- 5.1. Хорооны дарга (эсхүл тохоон томилогдсон гишүүн) Хорооны үйл ажиллагаа, дүгнэлт, зөвлөмжийг ТУЗ-д тогтмол тайлagnана.

Зургадугаар зүйл. Бусад

- 6.1. Хороо нь энэхүү дүрмийг хоёр жил тутамд хянаж, хууль тогтоомжийн шаардлага, засаглалын шилдэг туршлага болон байгууллагын хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлнэ. Хороо аливаа өөрчлөлтийн саналыг ТУЗ-д танилцуулж, батлуулна.

-о0о-